

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтын хүрэх үр дүнг стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх гэж, мөн Бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрэх үр дүнг хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх гэж тус тус тодорхойлсон.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үүнд Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барихаар тусгасан. Мөн хөтөлбөрт хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэх зорилтыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолыг баталсан.

- Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай хэлэлцээ хийсний үр дүнд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр амжилттай байгуулсан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т Улсын Их Хурал “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг

байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;”-г заавал соёрхон батална гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Засгийн газар гарын үсэг зурсан заавал соёрхон батлах хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, тухайн гэрээний эх бичвэрийн хуулбар, шаардлагатай бол тухайн олон улсын гэрээний энэ хуулийн 7.4, 7.5-д заасны дагуу хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга болон холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус хуульчилсан байна.

Иймд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын биелэлтийг хангах, түүнчлэн Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээг нэмэгдүүлж төсвийн орлого, валютын нөөцийг өсгөх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордыг иж бүрэн ашиглах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх боломжийг тус тус бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулан, өргөн мэдүүлж байна.

Нэг. Тус хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

Уг хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага нь дараах боломж, нөхцөлийг бий болгоход оршино. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын биелэлтийг хангах;

- Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээг нэмэгдүүлж төсвийн орлого, валютын нөөцийг өсгөх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордыг иж бүрэн ашиглах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд БНХАУ-тай хоёр дахь төмөр замын гарцыг бий болгох;

- Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нь Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гашуунсухайт төмөр замын өртөө болон БНХАУ-ын ӨМӨЗО-ы Баяннуур хотын Урадын дунд хошууны нутаг дахь Ганцмод төмөр замын өртөө хооронд байрлах ба 1-р зэрэглэлийн, 1520 мм өргөн цариг, 1435 мм нарийн царигийн хос замтай, гол замын урт 19,5 км, өргөн царигаар жилд 30 сая.тн, нарийн царигаар жилд 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно. Түүнчлэн хил дамнасан төмөр зам нь 8-31 метр хүртэл өндөртэй, нийт 9,5 км урт стакадан гүүрэн байгууламж байхаар төлөвлөгдсөн бөгөөд гүүрний дам нурууг машинаар тавих технологи нь Монгол Улсад нэвтрээгүй тул БНХАУ-ын урьд өмнө ижил төстэй ажил гүйцэтгэж байсан дадлага, туршлага бүхий, шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн нөөцтэй компаниар гүйцэтгүүлэх.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай" тусгасан болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн

Энэхүү хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар:

- Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах, дунд болон урт хугацааны нүүрс олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж төсвийн орлого, валютын нөөцийг өсгөх, Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордыг иж бүрэн ашиглах, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам баригдаж тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх боломж бүрдэх;

- Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бүс нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжих;

- Төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш, Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдүүлэх, ядуурлын түвшин бууруулж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих боломжийг бүрдүүлэх зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар цаашид Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулах ажлыг эхлүүлснээр Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замыг байгуулах нөхцөл бүрдэнэ.

Эдгээр шаардлагын улмаас "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай" хуулийн төслийг боловсрууллаа.

Дөрөв. Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан болно.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд үүний нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 2024 оны 58 дугаар тогтоолыг баталсан бөгөөд үүний дагуу “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулаад байна. Хэлэлцээр байгуулагдсанаар Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын хамтын ажиллагаа эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарт өргөжиж, улмаар худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, түүнчлэн олон улсын ба бүс нутгийн хамтын ажиллагаа идэвхжих ач холбогдолтой юм.

Иймд Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 8.1.3 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр боловсрууллаа. Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай” заалт байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай тус тус нийцсэн болно.

--ooOoo--